



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2020 оны 05 сарын 19 өдөр

Дугаар 278

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1, 5.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй хавсралтад заасан нийт 59,900,000.00 (тавин есөн сая есөн зуун мянга) төгрөгийн балансын үнэ, 22,254,513.77 (хорин хоёр сая хоёр зуун тавин дөрвөн мянга таван зуун арван гурван төгрөг далан долоон мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий автомашиныг Нийслэлийн Сүхбаатар дүүргийн Прокурорын газарт балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Дэд дарга А.Дагвадорж, Нийслэлийн Сүхбаатар дүүргийн Прокурорын газрын ерөнхий Прокурор, хууль цаазын шадар зөвлөх Э.Амарбат нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Автомашины улсын дугаарыг бүртгэлээс шилжүүлсэн тодорхойлолт, арга хэмжээний биелэлтийг 2020 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА


З.МЭНДСАЙХАН

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Д.НАРАНГЭРЭЛ



300438



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны ... дугаар сарын 19 өдрийн
... дугаар тогтоолын хавсралт

**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ
СҮХБААТАР ДҮҮРГИЙН ПРОКУРОРЫН ГАЗАРТ БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ АВТОМАШИЙН**

д/д	Хөрөнгийн нэр	Үйлдвэрлэсэн /ашиглалтад орсон огноо	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	Ниссан Теана маркийн, 0143 УБЗ арал IN4AL3AP4GC188609	2016/2019	ш	1	59,900,000.00	22,254,513.77	37,645,486.23
	Нийт дүн				59,900,000.00	22,254,513.77	37,645,486.23
					(тавин есөн сая есөн зуун мянга)	(хорин хоёр сая хоёр зуун тавин дөрвөн мянга таван зуун арван гурван төгрөг далан долоон мөнгө)	(гучин долоон сая зургаан зуун дөчин таван мянга дөрвөн зуун наян зургаан төгрөг хорин гурван мөнгө)